

ОЮУН УХААНЫ ХӨГЖЛИЙН ТӨВШИНГ ТОДОРХОЙЛСОН ДҮНГЭЭС

Д.Саруул

Хураангуй

Америкийн сэтгэл зүйч Д. Векслерийн сорилын тухай товч авч үзэж, энэхүү сорилоор ЕБС-ийн дунд ба ахлах ангийн сурагчдын оюун ухааны хөгжлийн төвшинг тогтоосон тухай өгүүлнэ.

Судалгааны зорилго: Дунд ба ахлах ангийн суралцагчдын оюун ухааны хөгжлийн ерөнхий төвшинг Д.Векслерийн сорилоор тогтоох

Дэвшүүлсэн таамаглал: Оюун ухааны хөгжлийн төвшингийн үзүүлэлт, анги ахих тусам өсөх ба хэвийн тархалтын зүй тогтолд захирагдана.

Судалгааны арга зүй: Америкийн сэтгэл зүйч Д.Векслерийн боловсруулсан WAIS; WISC аргачлал.

WAIS - Wechsler Adult Intelligence Scale

WISC – Wechsler Intelligence Scale Children

Д. Векслер WAIS, WISC аргачлалыг бүтээхдээ оюун ухааны дараахь ойлголтонд тулгуурласан.

Оюун ухаан гэдэг нь ухаалгаар ажиллаж, оновчтой сэтгэн, амьдралын нөхцөл байдлын учир зүйг сайтар олох ерөнхий чадвар товчоор хэлбэл “орчинтойгоо харьцахдаа хүчээ зөв зохицуулах” чадвар.

Ухаантай хүн гэж юмыг зөв шүүж, ойлгож, ухаарч эрүүл ухаан, идэвх санаачилгынхаа ачаар амьдралын нөхцөл байдалд дасан зохицож чадаж буй хүнийг хэлэх ажээ. Өөрөөр хэлбэл дасан зохицох чадварыг оюун ухаан гэнэ.

Оюун ухааны 3 талыг онцолсон.

- Суралцах чадвар
- Дасан зохицох чадвар
- Хийсвэр сэтгэлгээний чадвар

Д.Векслерийн сорил 2 хувилбартай.

1939 онд насанд хүрэгчдийн оюун ухааныг хэмжих тестийг (WAIS) (16-64 нас)

1949 онд хүүхдийн оюун ухааныг хэмжих тестийг (WISC) (6-15 нас) тус тус зохиожээ.

Эдгээр нь үгэн ба үгэн бус тестийн аль алиныг агуулдаг. Үгэн ба үгэн бус тестүүд өдөөгч материалын шинжээрээ ялгаатай.

Тест оношилгооны явцад туршигдагчийн хэрэглэх материалыг “өдөөгч материал” гэж нэрлэнэ.

Энэ сорилын насанд хүрэгчдийн хувилбар 11 дэд сорилоос, хүүхдийн хувилбар нь 12 дэд сорилоос бүрдэг. Д.Векслерийн сорилын насанд хүрэгчдийн хувилбарын даалгавраас болон дэд сорил тус бүрийн сэтгэл зүйн тодорхойлолт нөлөөлөх хүчин зүйлийн талаар хүснэгтээр харуулья.

Хүснэгт 1. Векслерийн сорилын (WAIS) даалгавар [жишээ]

Үгэн даалгавар	Үгэн бус даалгавар
1. Мэдлэг (29 багц асуултын 6-р Ж нь): Ус хэдэн хэмд буцалдаг вэ?	7. Шифрлэх (90 сек тоо бүрт харгалзах дүрсийг олж тавих)
2. Ойлгоц (14 багц асуултын 5-р нь) Та өдрийн цагаар ой модонд төөрвөл ой модноос гарахын тулд хаашаа явах вэ?	8. Дутууг гүйцээ (ямар нэг эд анги нь дутуу 20 ширхэг зураг буй дутуу зүйлийг нь олно) Жишээ нь сүүлгүй гахай мэт
3. Арифметик (14 багц асуултын 4-р нь) Нэг хүн 60 төгрөгний харандаа авахдаа худалдагчид 100 төгрөг өгсөн байна. Тэр хүн хэдэн төгрөгний хариулт авах вэ?	9. Косын шоо (1-10 ширхэг зургийг шоогоор эвлүүлэх)
4. Адил төсөө (13 багц асуултын 3-р нь) Сүх хөрөө хоёр юугаараа төсөөтэй вэ?	10. Зургаар үйл явдал бүтээх (Зургуудыг үйл явдлыг харуулсан дарааллаар байрлуулна. Жнь: загас барих гэх мэт)
5. Тоог давтах (9 даалгаврын 5 дахь нь) 4-2-7-3-1 цифрүүдийг давт тоонуудыг давт. Гэхдээ урвуу дарааллаар давт.	11. Дүрс эвлүүлэх (хэсгүүдээс бүхлийг бүтээх)
6. Толь бичиг (40 багц асуултын 5 -р нь) Өвөл гэж юу вэ?	

Хүснэгт 2. Д. Векслерийн сорилоор тодорхойлогдох оюун ухааны үйлдлүүд

Сорилууд	Судлагдах үйлдлүүд	Үр дүнд нөлөөлөх хүчин зүйлүүд
Ердийн мэдлэг	Мэдээллийг ойд хадгалах чадвар, мэдлэг туршлагаа ашиглах	Сонирхол, орчин
Ойлгоц	Хийсвэр сэтгэлгээ, мэдлэгээ ашиглах ойлголт төлөвших	Орчинтой харьцах боломж, бодит байдалд хариу өгөх байдал, анхаарлын багтаамж
Арифметик	Арифметик үйлдлүүдийг ой ухаандаа хадгалах	Математикийн үндсэн үйлдлүүдийг эзэмшсэн байдал
Адил төсөө	Үгэн ойлголтын төлөвшилт юмс хоорондын харилцан уялдааг задлан шинжлэх	Орчин
Толь бичиг	Ойлголт төлөвших, хэлний хөгжил	Орчин
Тоон цуваа	Түргэн хугацаанд сэргээн санах чадвар, сонсголын дүрслэл (харааны мэдэрхүй)	Анхаарлын багтаамж
Зурган дараалал	Харж хүртэх чадвар	Орчин
Дутууг гүйцээх	Харааны хүртэхүй, задлан шинжлэх чадвар, харааны дүрслэл	орчин тойрноо хүртэх туршлага
Дүрс эвлүүлэх	Харааны хүртэхүй, нэгтгэн дүгнэх чадвар, хараа болон холбож зохицуулах түвшин чадвар	хөдөлгөөний идэвхийн тодорхой чанар болон түвшин

Косын шоо	Хэлбэр хүртэх, харааны хүртэхүй, задлан шинжлэл хийх чадвар, хараа хөдөлгөөний эвсэл	Өнгөт харааны түвшин, хөдөлгөөний идэвхийн зэрэг
Шифрлэх	Түргэн хугацаанд сэргээх санах чадвар хараа хөдөлгөөний холбоо, харааны дүрслэл	хөдөлгөөний идэвхийн зэрэг

Судалгааны түүвэр, зохион байгуулалт: Судалгаанд Ховд аймгийн ЕБС-ийн 7-р сургуулийн 13-18, насны 378 суралцагч хамрагдлаа. Эдгээр судлагдагчдыг нас хүйсээр нь ангилан авч үзвэл:

Хүснэгт 3.

Эрэгтэй	Эмэгтэй	13-15 нас (Өсвөр нас)	16-18 нас (Орь залуу нас)
41,2%	58,8%	49,6%	50,4%

Судалгааг ганцаарчлан зохион байгуулсан бөгөөд өсвөр насны 1 суралцагчийг цаг 28 минутанд, орь залуу насны 1 суралцагчийг дунджаар 1 цаг 10 минутанд багтаан сугалсан. Судалгааны дүнгээс:

Д.Векслерийн сорилын дагуу IQ үзүүлэлтүүдийн тайлбарыг дараахь схемийн дагуу хийнэ.

Хүснэгт 4

Үзүүлэлтийн үнэлгээ	Оюун ухааны хөгжлийн төвшин	Түүвэрт эзлэх хувь
130 ба түүнээс дээш	Маш өндөр	2,2%
120-129	Өндөр	6,7%
110-119	Хэвийн сайн	16,1%
90-109	Дундаж төвшин	50%
80-89%	Дундаас доогуур төвшин	16,1%
70-79%	Эргэлзээт хязгаарлагдмал	6,7%
69 ба түүнээс доош	Оюуны хоцрогдол	2,2%

Өсвөр ба орь залуу насныхны оюун ухааны хөгжлийн дундаж төвшинг тогтоосон.

Хүснэгт 5


Үзүүлэлт ангилал	Насны	Үгэн IQ	Үгэн бус IQ	Ерөнхий үзүүлэлт IQ
Өсвөр нас		106	101	104
Орь залуу нас		108	102	106

Энэ хүснэгтээс харахад өсвөр ба орь залуу насныхны оюун ухааны хөгжлийн ерөнхий төвшин “дундаж” төвшинд байна гэж тогтоогдсон. Орь залуу насныхны үгэн, үгэн бус, ерөнхий үзүүлэлт өсвөр насны суралцагчдын үзүүлэлтээс өндөр гарсан нь харагдаж байна. Эндээс оюун ухааны хөгжлийн төвшин нь хүүхдийн нас, мэдлэгийн хэмжээ, амьдралын туршлага, онцлог, дасан зохицох чадвартай холбоотойгоор байнга өөрчлөгдөж өсөж хөгжиж байдаг динамик зүй тогтолтой юм байна гэсэн дүгнэлт хийж болох ба бидний тавьсан таамаглалыг баталж байна. Мөн өөр нэг онцлог нь бол аль ч насны хүүхдүүдийн үгэн чадвар үгэн бус чадвараасаа ялигүй өндөр гарчээ. Энэ бол манай ард түмний эртнээс нааш уламжилж ирсэн соёл, түүх, үлгэр домог ярих, ерөөл магтаал цээжлэх, оньсого таавар таах зэрэг өв уламжлалтай холбоотой байх талтай. Өсвөр ба орь залуу насныхны оюун ухааны хөгжлийн төвшингийн тархалтыг судалсан бөгөөд жишээ болгон өсвөр насны суралцагчдын тархалтыг авч үзье.


Хүснэгт 6. Дунд ангийн суралцагчдын оюун ухааны хөгжлийн төвшний

	Маш өндөр (130+)	Өндөр (120-129)	Хэвийн сайн (110-119)	Дундаж (90-109)	Дунджаас доогуур (80-89)	Эргэлзээт (70-79)	Оюуны эмгэг (69-)
13 нас	0	2	1	6	0	0	0
14 нас	2	5	13	27	8	1	1
15 нас	1	5	7	32	6	1	1
Бүгд	3	12	21	65	14	2	2
Эзлэх хувь	2.52	10.08	17.65	54.62	11.76	1.68	1.68
Стандарт Хязгаар (Векслер)	2.2	6.7	16.1	50	16.1	6.7	2.2

Диаграмм 1. Дунд ангийн суралцагчдын оюун ухааны хөгжлийн төвшний үзүүлэлт



Диаграмм 2. өсвөр ба орь залуу насныхны дэд сорилуудын үнэлгээг харьцуулан авч үзвэл:



Дээрх хүснэгт 6 болон диаграмм 1-с харахад өсвөр насныхны оюун ухааны төвшингийн тархалт өндөр болон хэвийн сайн тал руугаа тархалт ихтэй, дунджаас доогуур тал руугаа тархалт нь бага байгаа нь харагдаж байна. Энэ зүй тогтол орь залуу насныхны оюун ухааны төвшингийн тархалтын зүй тогтлыг давтан гарч байгаа билээ. Эндээс бид дараах дүгнэлтийг хийж байгаа юм.

Монгол хүний оюуны чадамж өндөр байх магадлалтай гэсэн зарим эрдэмтдийн таамаглал нийцэж байгаа бөгөөд хэвийн тархалтын муруйд захирагдана гэсэн бидний таамаглал ерөнхийдөө батлагдаж байна.

Хүний нийгмийн үйл ажиллагааны олон талыг хамарсан асуудлуудыг өөртөө багтаах ба амьдралын туршлага дээрээ үндэслэн эрүүл сэтгэж Оюун дүгнэлт гаргах чадварыг нь илрүүлдэг, туршигдагчаас зан үйлийн зарим ерөнхий зүй тогтол болон дүрмийн ойлгоцыг шаарддаг дэд сорил болох "Ойлгоц"-ыг аль ч насны суралцагчид хамгийн сайн гүйцэтгэсэн байна. Өөрөөр хэлбэл дунд ба ахлах ангийнхны дасан зохицох чадвар өндөр байгааг илтгэж байгаа үзүүлэлт гэж үзэж бадэйдна. Бусад сорилуудыг дундаж болон түүнээс ялимгүй дээгүүр төвшинд гүйцэтгэсэн байна.

Дунд ангийн суралцагчдын материалаас 75 хүүхдийн материалыг сонгон авч дэд сорил бүрийн хүндрэлийн индексийг бодож даалгавруудад анализ хийж үзсэн юм. Жишээ болгон "Ойлгоц" дэд сорилыг даалгаврын гүйцэтгэлд хийсэн анализыг оруулъя.

Хүснэгт 7. Дэд сорил 2 “Ойлгоц”

	хуруу	Тоглоом	Дэлгүүр- боов	Зодоон	Тоосго байшин	Гэмт хэрэгтэн	Эмэгтэйчүү д ба	Мөнгө банк	Ломбард	Их сурууль шалгалт	Хуванцар мод	Их хурлын гишүүд	Амлалт	Зам
2 оноо	71	71	69	64	23	48	29	62	55	35	28	37	48	66
1 оноо	4	3	2	7	40	18	31	8	8	23	34	23	12	2
Оноо	0	1	4	4	12	9	15	5	12	17	13	15	15	7
Эзлэх хувь	10 0	96.6	94.5	94.1	65.7	84.2	65.9	92.5	82	67.3	68.2	77.1	76.1	90.4
Үр өгөөж ийн	1	0.9	0.9	0.9	0.6	0.8	0.6	0.9	0.8	0.6	0.6	0.7	0.7	0.9

Ойлгоц дэд сорилын далгаврын хүндрэлийн индекс 0.77.

“Ойлгоц” 2-р дэд сорил түүврийн соёлын ялгааг хамгийн их тусгадаг. Энэхүү сорилоор туршигдагчаас нийгмийн зан үйлийн зарим ерөнхий зүй тогтол болон дүрмийн ойлгоц, хийсвэр сэтгэлгээ мэдлэгээ ашиглах чадвар, бодит байдалд хариу өгөх байдал зэргийг судална. “Ойлгоц” дэд сорилын даалгавруудаас хүндрэлийн индекс дунджаар 0.7 байгаа нь сэтгэц хэмжил зүйчдийн тэмдэглэн заасантай тохирч байна. Гүйцэтгэлийн хувиас харахад даалгаврууд хөнгөнөөс хүндэрсэн дарааллаар өгөгдсөн. Дунд ангийн сурагчдын “Ойлгоц” дэд сорилын стандарт онооны дундаж 14 гарсан байна. Энэ насныхан энэ дэд сорилыг бусад дэд сорилуудтай харьцуулахад харьцангуй сайн гүйцэтгэсэн. Иймд дунд ангийн сурагчдын хийсвэр сэтгэлгээ, өмнөх мэдлэгээ ашиглах чадвар, нийгмийн зан үйлийн ерөнхий зүй тогтол болон дүрмийн ойлголтоо бодит байдалд хариу өгөх чадварууд харьцангуй сайн хөгжсөн. Энэ сорилын зарим асуултанд хүүхдүүдийн өгсөн сонирхолтой хариултаас оруулъя. Энэхүү сорилын даалгавруудын гүйцэтгэлийн үр дүнд хүүхдийн зан төлөвийн хувийн онцлог илүү их нөлөөлж байгаа юм шиг санагдсан юм.

Чанарын судалгаа 1.

2008.8. 10. 15 цаг 36 мин

Сурагч3. 15 настай, эм. Маш сэргэлэн хөдөлгөөнтэй охин. Хичээл дээр тогтвортой

томоотой суудаггүй. нааш цааш эргэн бусадтай

ярьж инээж байдаг. Алхаа гишгээ, үг яриа нь түргэн, сэтгэлийн хөдөлгөөн ихтэй. Шинэ зүйлд амархан татагддаг. Уншсан ном, үзсэн киноныхоо талаар сэтгэл догдлон ярьдаг. Хичээл дээр гарах шинэ сонин зүйл бүрт хүчтэй татагдах боловч сонирхол нь амархан буурдаг. Сонирхол нь тогтворгүй. Сэтгэлийн хөдөлгөөний гадаад илрэл сайн. Нүүрийг нь хараад л сэтгэл санаа нь ямар байна, хичээлд хэрхэн хандаж байна вэ гэдгийг нь тодорхойлон хэлэх боломжтой. Сонирхсон хичээлдээ маш үр дүнтэй оролцдог. Сонирхолгүй бол юу ч хийдэггүй, багшийн яриаг ч сонсохгүй бусадтай ярьж суудаг. Хангалтгүй дүн авсан үедээ уйлахад ч бэлэн боловч хагас цаг ч болоогүй байхад түүнийгээ мартчихаад хөгжилтэй юм ярьж инээж явдаг. Хөдөлгөөнтэй сэргэлэн боловч сахилга дэг журам зөрчдөггүй.

Баримт:1. Хичээлээ тараад гэртээ иртэл танай талх боов дууссан байвал яах вэ?

Сурагч3: Гэрийнхээ доод давхрын таньдаг худалдагч эгчээс зээл авч идчихээд ээждээ хэлнэ.

Судлаач: Худалдагчийг танихгүй бол яах вэ?

Сурагч3: Шууд хоол хийж иднэ.

2.Замаар дөхөж ирж байгаа машины зам үерт сэтэрч гүнзгий ангал үүссэнийг чи мэдвэл яах вэ?

Сурагч3. 2 гартаа нэг нэг хувцсаа тайлж бариад 2 гараараа даллаад зам дээр нь зогсоно. Хашгирна. Доороо дэвхцэнэ гэж хариулжээ.

Одоо сурагч Б яаж хариулсаныг үзье. 2008.9.7 14 цаг 00 минут.

Сурагч Б. 15 настай эр. Учир битүүлэг зожигдуу зантай, хичээл дээр тайван нэгэн хэвийн байдлаар сурдаг. Дуу цөөнтэй. Зөрүүд гөжүүд зантай. Найз нөхөд цөөнтэй. Тоглоом даадаггүй уурладаг.

Баримт 3. Замаар дөхөж ирж байгаа машины зам үерт сэтгэрч гүнзгий ангал үүссэнийг чи мэдвэл яах вэ?

Сурагч Б: Яах ч үгүй. Холдож зогсоод харна.

Судлаач: Машиныг зогсоохгүй юу?

Сурагч Б: Үгүй

Баримт 4: Чи хүүхдийн бөмбөгөөр тоглож байгаад гээчихвэл яах вэ?

Сурагч Б: Би гээчихлээ гээд эзэнд нь хэлнэ.

Баримт 5. Нуруугаараа чамаас намхан хүү/охин/ чамтай зодолдох гээд байвал чи яах вэ?

Сурагч Б: Түлхэнэ. Гарыг нь барина. Хариуг нь өгнө гэж хариулжээ.

ДҮГНЭЛТ

Шинжлэх ухааны үндэслэл бүхий судалгааны арга зүйг сонгон хэрэглэж, монголын суралцагчдын оюун ухааны хөгжлийн төвшинг нэг аймгийн тодорхой тооны судлуулагчдын хүрээнд анх удаа судлан бодитойгоор тогтоосон судалгаагаар дунд ангийн суралцагчдын оюун ухааны стандарт үнэлгээний дундаж төвшин 105,76 ахлах ангийн сурагчдын стандарт үзүүлэлт 113,92 байгаа нь олон улсын стандарт үзүүлэлттэй үндсэндээ тохирч байна. Бидний судалгаанд оролцсон дунд ангийн суралцагчдын стандарт онооны дундаж утга нь оюун ухааны хөгжлийн дундаж хэвийн төвшинг илтгэж байхад ахлах ангийн суралцагчдын стандарт онооны дундаж утга оюун ухааны хөгжлийн хэвийн сайн төвшинг илтгэж байна.

Дунд ба ахлах ангийн суралцагчдын ангилалд үгэн оюун ухааны төвшин үгэн бус оюун ухааны төвшнөөс ялимгүй дээгүүр гарсан байна.

Бид үгэн ба үгэн бус үзүүлэлтүүд, үгэн үзүүлэлт ба ерөнхий үзүүлэлт, үгэн бус үзүүлэлт ба ерөнхий үзүүлэлтийн хоорондын корреляцийн коэффициентийг тооцож гаргасан бөгөөд 0.60 /0,52/, 0,91 /0,89/, 0,87

/0,77/ утга бүхий гарсан нь үзүүлэлтүүдийн хоорондын харьцангуй хүчтэй хамаарлыг илэрхийлж байна. Түүнчлэн бид оюун ухааны хөгжлийн ерөнхий төвшин ба жилийн ерөнхий дүн, оюун ухааны хөгжлийн төвшин ба математикийн жилийн дүн болон математикийн хичээлийн шалгалтуудын үр дүнтэй холбоо хамааралтай болохыг тогтоов. Үүнээс суралцагчдын математикийн хичээлийн дүн тэр тусмаа ахисан шатны мэдлэгийн төвшин оюун ухааны ерөнхий төвшинтэй төдийлөн хамаатай биш бөгөөд харин жилийн эцсийн 18 хичээл дунджаар гаргасан үнэлгээ ба ерөнхий стандартүнэлгээ шууд хамааралтай гэсэн дүгнэлт хийж болох юм.

НОМЗҮЙ

1. Мягмар О. Хувийн дасан зохицохуй. УБ.2001.
2. Мягмар О, Дашхүү.Д. нар. Өсвөр , ахлах насны хүүхдийг судлах арга зүй УБ.,2006.
- 3.Мягмар О. Сэтгэл судлал 1. УБ. 2008.
4. Мягмар О. Сэтгэл судлал 2. УБ. 2008.
5. Сэтгэл судлал /Хамтын бүтээл/ ред. Мягмар О, УБ., 2001.
6. Туяа.Б. Тестийг зохицуулан хэрэглэх туршилт судалгаа /Оюун ухааны бүтцийг оношлох Р.Амтхауэрын тестийн жишээн дээр/ Диссертаци УБ., 2006.
7. Туяа.Б. Хишиг-Ундрах. Б. Тест судлал УБ.,2005.
8. Цэрэндондов П, Чимэдлхам Ч. Сурган-сэтгэл зүйн судалгааны баримтад статистик задлан шинжилгээ хийх арга УБ., 2008.
9. Цэрэндондов П, Оюун ухаан ба танин мэдэх зарим үйл явцыг судлах арга зүй, УБ 2009.
10. Цэрэндондов Спортын сэтгэл судлалын судалгааны зарим арга зүй УБ., 2009.
11. Эрдэнэчулуун.Д. Хүүхдийг судлах арга зүй Нэгдүгээр дэвтэр, УБ., 2008.
12. Эрдэнэчулуун.Д. Хүүхдийг судлах арга зүй Хоёрдугаар Дэвтэр, УБ., 2008.
13. Эрдэнэцэцэг С. Ph. Докторын диссертаци /зөвлөмж ба удирдамж/ УБ.,2009.
14. Филимоненко Ю.И, Тимофеев В.И. Тест Д.Векслера: диагностика структуры интеллекта. Методическое руководство. Г.П."ИМАТОН" 2002.
15. Research Methods in Psychology John J. Shaughnessy, Eugene B.Zechmeister Boston 1997.
16. Internet site: <http://psychology/wadsworth.com> Be Careful of How You Define Intelligence.
17. The Knowns and Unknowns of Intelligence.